10

# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2009 оны 06 сарын 25 өдөр Дугаар 268 Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 тоот тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Лхагвадорж овогтой Өнөрийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын York их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр 1 жил, Сэнгээ овогтой Гандуламыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Калифорнийн олон улсын их сургуулийн магистрантурт инновацийн бодлогын чиглэлээр, Сүмбэрзул овогтой Цолмонг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Финлянд Улсын Хельсинкийн их сургуулийн магистрантурт олон улсын эрх зүйн чиглэлээр, Цамба овогтой Батмандахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Шинэ Зеланд Улсын Auckland их сургуулийн магистрантурт аялал, жуулчлалын менежментийн чиглэлээр, Рэгзэн овогтой Шинэгэрэлийг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Австрали Улсын Queensland их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Намчин овогтой Мөнхзулыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Birkbeck их сургуулийн магистрантурт соёл, урлагийн удирдлагын чиглэлээр, Сэнгээ овогтой Гантуяаг Эрүүл мэндийн яамны захиалгаар Малайз Улсын Кебангсаан их сургуулийн магистрантурт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний

удирдлагын чиглэлээр, Цэгмид овогтой Хүрэлбаатарыг Тагнуулын ерөнхий газрын захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Жорж Мэйсоны их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр, Бадрах овогтой Цолмонбаярыг Улсын Их Хурлын Тамгын Газрын захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Бриджпортын их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр, Бүрэнтогтох овогтой Жаргаланг Америкийн Нэгдсэн Улсын Иелийн их сургуулийн магистрантурт археологийн чиглэлээр, Дорж овогтой Ариунболдыг МОНЦАМЭ агентлагийн захиалгаар Австрали Улсын Charles Sturt их сургуулийн магистрантурт Мэдээллийн технологийн чиглэлээр, Амарсанаа овогтой Молор-Эрдэнийг Гадаад харилцааны яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Fairleigh Dickinson их сургуулийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр, Төмөрбаатар овогтой Мөнгөнцэцэгийг Сангийн яамны захиалгаар Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотын Де Врай их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Энх-Амгалан овогтой Золжаргалыг Улсын Их Хурлын Тамгын Газрын захиалгаар Япон улсын Waseda их сургуульд эдийн засгийн чиглэлээр, Энхтайван овогтой Одонг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Австри Улсын Вениийн их сургуульд мэдээллийн технологийн чиглэлээр, Содномпил овогтой Дэлгэрийг Улаанбаатар хотын захиргааны захиалгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тонжий их сургуульд барилга, архитектурын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2009-2010 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2.Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 тоот тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай

САЙД Ё.ОТГОНБАЯР